



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 11 сарын 23 өдөр

Дугаар A/787

Булган сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Оросын холбооны улсын Закаменск хотноо зохион байгуулагдах волейболын залуучуудын аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг тамирчдын замын зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Замын зардалд шаардагдах 3,048,000 (гурван сая дөчин найман мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  БАРИУН-ЭРДЭНЭ